



## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2023/18/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын  
дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган  
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn  
Аудитын менежер: Х.Женисбек  
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn  
Ахлах аудитор: Х.Манаргүл  
Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал .....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.5.1 Завсрын аудитын талаар .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	18
5.1 Төлбөрийн акт .....	18
Цалингийн урьдчилгааг суутгаж аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.....	18
5.2 Албан шаардлага .....	19
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgi@audit.gov.mn

АЛТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
А.ОЗАТ ТАНАА

᠒᠐᠒3-᠐᠒.᠒4 № ᠒᠒3  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны төсөв өмнөх оноос 154.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

#### Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

#### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>11,184,640.00</u></b>	<b><u>11,326,084.00</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	141,444.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	141,444.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	141,444.00
31211	Төрийн сангийн харилцах		21,444.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах		120,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	11,184,640.00	11,184,640.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	11,184,640.00	11,184,640.00
35420	Аж ахуйн материал	9,761,000.00	9,761,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,423,640.00	1,423,640.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,210,948,596.13</u></b>	<b><u>1,219,842,943.23</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,210,948,596.13	1,219,842,943.23
391	Газар		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,204,056,596.13	1,212,950,943.23
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,046,701,033.56	1,168,102,202.77
39202	Хуримтлагдсан элэгдэл	(259,174,656.00)	(317,328,160.25)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	197,290,000.00	209,290,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(162,800,624.77)	(181,351,666.79)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	327,977,980.00	342,977,980.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(173,968,286.62)	(199,018,735.63)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,848,820.00	41,848,820.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,828,758.15)	(17,988,934.90)
39209	Зам, гүүрийн байгууламж	267,703,144.00	267,703,144.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(139,646,523.40)	(162,793,811.32)
39214	Бусад үндсэн хөрөнгө	131,664,351.13	131,664,351.13
39215	Хуримтлагдсан элэгдэл	(58,105,783.62)	(70,550,145.78)
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном	395,900.00	395,900.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	6,892,000.00	6,892,000.00
39301	Програм хангамж		
39302	Хуримтлагдсан элэгдэл		
39303	Бусад биет бус хөрөнгө	8,752,947.00	8,752,947.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,860,947.00)	(1,860,947.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,222,133,236.13</u></b>	<b><u>1,231,169,027.23</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b><u>2,821,380.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	2,821,380.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	2,821,380.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		2,821,380.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,222,133,236.13</u></b>	<b><u>1,228,347,647.23</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,222,133,236.13	1,228,347,647.23

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	452,639,918.40	452,639,918.40
51101	Өмч: - төрийн	452,639,918.40	452,639,918.40
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>525,741,850.17</b>	<b>531,956,261.27</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	525,741,850.17	525,741,850.17
51220	Тайлант үеийн үр дүн		6,214,411.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	243,751,467.56	243,751,467.56
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,222,133,236.13</u></b>	<b><u>1,231,169,027.23</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>484,756,680.00</b>	<b>701,558,869.21</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>484,756,680.00</b>	<b>701,558,869.21</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	94,199,185.00	138,401,169.21
131005	Хөрөнгийн санхүүжилт	94,199,185.00	138,401,169.21
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,310,995.00	21,121,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,310,995.00	21,121,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	387,246,500.00	542,036,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	387,246,500.00	513,365,300.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		28,671,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>506,999,719.72</b>	<b>695,344,458.11</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>506,999,719.72</b>	<b>695,344,458.11</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	506,999,719.72	619,366,388.11
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	251,430,600.00	269,617,180.00
210101	Үндсэн цалин	175,350,928.00	198,071,344.00
210102	Нэмэгдэл	45,629,369.00	40,160,350.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал		1,456,510.00
210105	Гэрээт ажлын хөлс	30,450,303.00	29,928,976.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,552,700.00	32,565,200.00
210201	Тэтгэврийн даатгал	22,907,500.00	22,725,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,411,300.00	2,400,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,929,000.00	1,679,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	482,300.00	523,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,822,600.00	5,236,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	23,127,100.00	34,378,900.00
210301	Гэрэл, цахилгаан	1,164,800.00	565,000.00
210302	Түлш, халаалт	21,962,300.00	33,813,900.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,586,145.00	25,321,900.00
210401	Бичиг хэрэг	2,246,600.00	1,101,800.00

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	9,068,645.00	22,097,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,182,900.00	2,034,800.00
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	88,000.00	88,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	457,000.00	457,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	457,000.00	457,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,176,000.00	1,008,700.00
210604	Урсгал засвар	1,176,000.00	1,008,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,739,800.00	2,569,500.00
210702	Дотоод албан томилолт	2,739,800.00	2,569,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,263,800.00	1,557,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,400.00	472,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	302,200.00	362,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	90,300.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	178,900.00	168,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	398,700.00	350,800.00
210807	Газрын төлбөр	37,300.00	37,300.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	31,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	181,666,574.72	251,890,908.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,552,650.00	111,008,786.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	375,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	133,613,924.72	140,506,822.11
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	75,978,070.00
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	29,380,136.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		29,380,136.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	36,935,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		16,737,300.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		20,198,500.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	9,662,134.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		9,662,134.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(22,243,039.72)</b>	<b>6,214,411.10</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	589,000.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	589,000.00	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(589,000.00)	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(22,832,039.72)</b>	<b>6,214,411.10</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>390,557,495.00</u></b>	<b><u>563,157,700.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>390,557,495.00</b>	<b>563,157,700.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,310,995.00	21,121,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,310,995.00	21,121,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	387,246,500.00	542,036,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	387,246,500.00	513,365,300.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		28,671,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>377,457,495.00</u></b>	<b><u>552,016,256.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>377,457,495.00</b>	<b>552,016,256.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>375,385,795.00</b>	<b>476,747,426.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	251,430,600.00	266,795,800.00
210101	Үндсэн цалин	169,924,200.00	184,632,441.00
210102	Нэмэгдэл	50,397,100.00	44,771,959.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал		5,542,300.00
210105	Гэрээт ажлын хөлс	31,109,300.00	31,849,100.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,552,700.00	32,565,200.00
210201	Тэтгэврийн даатгал	22,949,400.00	22,092,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,403,100.00	2,618,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,912,000.00	2,094,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	550,500.00	523,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,737,700.00	5,236,400.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	23,087,100.00	34,588,900.00
210301	Гэрэл, цахилгаан	1,164,800.00	865,000.00
210302	Түлш, халаалт	21,922,300.00	33,723,900.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	13,016,395.00	24,978,800.00
210401	Бичиг хэрэг	2,247,600.00	1,101,800.00
210402	Тээвэр, шатахуун	9,497,895.00	21,754,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,182,900.00	2,034,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	88,000.00	88,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	457,000.00	457,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	457,000.00	457,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,176,000.00	1,008,700.00
210604	Урсгал засвар	1,176,000.00	1,008,700.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	2,739,800.00	2,569,500.00
210701	Гадаад албан томиллолт		

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	2,739,800.00	2,569,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,302,800.00</b>	<b>1,557,100.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,400.00	472,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	302,200.00	362,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	90,300.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	178,900.00	168,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	398,700.00	350,800.00
210807	Газрын төлбөр	37,300.00	37,300.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	70,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>49,623,400.00</b>	<b>112,226,426.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,123,400.00	111,851,126.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	375,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,071,700.00</b>	<b>75,268,830.00</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>28,670,896.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		28,670,896.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>36,935,800.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		16,737,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		20,198,500.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,071,700.00</b>	<b>9,662,134.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,071,700.00	9,662,134.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>13,100,000.00</u></b>	<b><u>11,141,444.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>13,100,000.00</b>	<b>11,000,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>13,100,000.00</b>	<b>11,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>13,100,000.00</b>	<b>11,000,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,100,000.00	11,000,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(13,100,000.00)</u></b>	<b><u>(11,000,000.00)</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>≡</b>	<b>≡</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>141,444.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>141,444.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	452,639,918.40	243,751,467.56	525,741,850.17		1,222,133,236.13
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>452,639,918.40</b>	<b>243,751,467.56</b>	<b>525,741,850.17</b>	<b>0.00</b>	1,222,133,236.13
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>452,639,918.40</b>	<b>243,751,467.56</b>	<b>525,741,850.17</b>	<b>0.00</b>	1,222,133,236.13
D01	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>452,639,918.40</b>	<b>243,751,467.56</b>	<b>525,741,850.17</b>	<b>0.00</b>	1,222,133,236.13
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>452,639,918.40</b>	<b>243,751,467.56</b>	<b>525,741,850.17</b>	<b>0.00</b>	1,222,133,236.13
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			6,214,411.10		6,214,411.10
D09	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>452,639,918.40</b>	<b>243,751,467.56</b>	<b>531,956,261.27</b>	<b>0.00</b>	1,228,347,647.23

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>542,036,500.00</b>	<b>532,352,922.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	542,036,500.00	532,352,922.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	476,429,500.00	466,746,226.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	266,795,800.00	266,795,800.00
210101	Үндсэн цалин	181,868,100.00	181,105,027.00
210102	Нэмэгдэл	47,536,300.00	48,299,373.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	5,542,300.00	5,542,300.00
210105	Гэрээт ажлын хөлс	31,849,100.00	31,849,100.00

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,565,200.00	32,565,200.00
210201	Тэтгэврийн даатгал	22,092,200.00	22,092,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,618,300.00	2,618,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,094,600.00	2,094,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	523,700.00	523,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,236,400.00	5,236,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,588,900.00	34,588,900.00
210301	Гэрэл, цахилгаан	865,000.00	865,000.00
210302	Түлш, халаалт	33,723,900.00	33,723,900.00
210303	Цэвэр, бохир ус		
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	15,241,500.00	15,207,600.00
210401	Бичиг хэрэг	1,101,800.00	1,101,800.00
210402	Тээвэр, шатахуун	11,983,000.00	11,983,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,068,700.00	2,034,800.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	88,000.00	88,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	457,000.00	457,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	457,000.00	457,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	1,008,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,008,700.00
2107	Томилолт, зочны зардал	2,239,500.00	2,239,500.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	2,239,500.00	2,239,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,741,600.00	1,557,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	529,200.00	472,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	362,200.00	362,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	90,300.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	178,900.00	168,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	398,700.00	350,800.00
210807	Газрын төлбөр	37,300.00	37,300.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	70,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	121,700,000.00	112,326,426.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	121,300,000.00	111,951,126.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	375,300.00

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,607,000.00	65,606,696.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	28,671,200.00	28,670,896.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	28,671,200.00	28,670,896.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,935,800.00	36,935,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,737,300.00	16,737,300.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,198,500.00	20,198,500.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>542,036,500.00</b>	<b>542,036,500.00</b>
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>439,036,500.00</b>	<b>542,036,500.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	410,365,300.00	513,365,300.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	28,671,200.00	28,671,200.00
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>103,000,000.00</b>	<b>-</b>
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	103,000,000.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		21,444.00
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>21</b>	<b>21</b>
620001	Удирдах ажилтан	3	3
620002	Гүйцэтгэх ажилтан	8	8
620003	Үйлчлэх ажилтан	7	7
620004	Гэрээт ажилтан	3	3
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>21</b>	<b>21</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	7
650010	Гэрээт ажилтан	3	3
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	2	2

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>21,001,200.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>21,001,200.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	21,001,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,771,200.00
210401	Бичиг хэрэг	
210402	Тээвэр, шатахуун	9,771,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	330,000.00
210701	Гадаад албан томилолт	
210702	Дотоод албан томилолт	330,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	10,900,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,900,000.00

<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	21,121,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	21,121,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,200,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,921,200.00
131106	Төсвийн урамшуулал	
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	120,000.00

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

#### *Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Алтай сумын Засаг даргын тамгын газар нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөгөө зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, Засаг даргын бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, ИТХ, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллага юм.

Алтай сумын Засаг даргын тамгын газрын зорилго нь: Удирдлага болон нөөцийн үр ашгийг дээшлүүлж төрийн үйлчилгээний шуурхай байдал чанар хүртээмжийг сайжруулах

Дээрх зорилгынхоо хүрээнд дараах зорилтыг тавьж ажилласан байна. Үүнд:

- Төрийн албаны болон холбогдох хууль тогтоомжуудыг ажилдаа мөрдлөг болгож, авлига, ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх
- Үйл ажиллагаандаа төрийн албаны стандартыг дагаж мөрдөн, дотоод ажлыг сайжруулах
- Ажлын цагийн ашиглалтыг сайжруулж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний ажлын хөнгөн шуурхай байдлыг хангах
- Байгууллагын санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд ил тод байдлыг хангаж ажиллах

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

#### *Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Алтай сумын Засаг даргын тамгын газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль бусад холбогдох хууль тогтоомжуудыг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Алтай сумын Засаг даргын тамгын газар нь НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөж ажилласан боловч даргын тушаалаар баталгаажуулаагүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9.0 сая төгрөгөөр буюу 0.7 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		141.5	141.5
Авлага			-
Урьдчилгаа			-
Бараа материал	11,184.6	11,184.6	-
Үндсэн хөрөнгө	1,210,948.6	1,219,842.9	8,894.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,222,133.2</b>	<b>1,231,169.0</b>	<b>9,035.8</b>
Өр төлбөр	-	2,821.4	2,821.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,222,133.2	1,228,347.6	6,214.4
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,222,133.2</b>	<b>1,231,169.0</b>	<b>9,035.8</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 0.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан, бараа материалын үлдэгдэлд өөрчлөлт гараагүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1219.8 сая төгрөг болж 8.9 сая төгрөгөөр өссөн нь 11.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, аймаг, сумын ОНХСан бүгд 138.4 сая төгрөгийн гэрэлтүүлэг, гүний худаг, багийн эмч нарын мотоцикл машин, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл 2.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь татварын өглөг нэмэгдсэнтэй холбоотой.

Тайлант онд 6.2 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 6.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 140.5 сая төгрөгийн хөрөнгийн элэгдэл байгуулжээ.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 385.0 сая, нийт зарлагыг 385.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны анх батлагдсан төсөв 391.0 сая төгрөг ба тодотгосон төсөв 542.0 сая төгрөг байна. Тодотгосон төсөв нь анх баталсанаас 151.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага гэсэн 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 41064 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 28.7 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, урьд оны үлдэгдлээс 103.0 сая төгрөгийн, бүгд 542.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 503.7 сая, орон нутгийн хөгжлийн сангаас 28.7 сая бүгд 532.4 сая төгрөгийн санхүүжилт олгож гүйцэтгэл 98.2 хувьтай байгаа нь 9.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар авч үзвэл цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардал 266.8 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 32.6 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 34.6 сая, хангамж, бараа материалын зардал 15.2 сая, нормативт зардал 0.5 сая, эд хогшил, урсгал засварын зардал 1.0 сая, томилолт, зочны зардал 2.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 1.6 сая, бусад бараа үйлчилгээний зардал 112.3 сая, засгийн газрын шилжүүлэг 28.7 сая, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал 16.7 сая, тэтгэвэрт гаргахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 20.2 сая, бүгд 542.0 сая төгрөг байна.

Нийт төсвийн зарлагын 50.1 хувийг цалингийн зардал, 6.2 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 6.5 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 2.9 хувийг хангамж, бараа материалын зардал, 12.3 хувийг урсгал шилжүүлэг, 21.1 хувийг бараа үйлчилгээний бусад зардал эзэлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	399,912.8	390,369.0	9,543.8	97.6
2	80102-Туслах үйл ажиллагааны зардал	63,516.7	63,398.4	118.3	99.8
3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж,	20,198.5	20,198.5	-	100.0
4	80815-Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөг	16,737.3	16,737.3	-	100.0
5	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	10,000.0	10,000.0	-	100.0
6	82801-Улсын их баяр наадам	3,000.0	2,978.9	21.1	99.3
7	83401-ОНХС - Итгэлцүүрээр олгох	28,671.2	28,670.9	0.3	100.0
	<b>Дүн</b>	<b>542,036.5</b>	<b>532,353.0</b>	<b>9,683.5</b>	<b>98.2</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд баяр наадмын зардалд 5.0 сая, мал тооллогын зардалд 2.1 сая, гэр бүлийн хүчирхийллийн зардалд 0.2 сая, гал түймрийн зардалд 9.0 сая, мод тарих зардалд 4.0 сая, аргалын өвсд 0.7 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл болох 0.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Алтай сумын Засаг даргын тамгын газар нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар

илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий ймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 21 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 509.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 5.1 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага бараа, ажил үйлчилгээний зардлыг хэмнэлттэй зарцуулсан байна. төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой зөрчил гараагүй болно.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Алтай сумын Засаг даргын тамгын газар нь 2022 онд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 61.1 сая төгрөгийн 25 шийдвэрийн талаарх мэдээллийг байршуулаагүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75% байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 97.0 сая төгрөгийн албан шаардлага өгөгдсөн ба биелэлтийг албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт  
4

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	4	97048.6	4	97048.6	100%
Зөвлөмж					
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>97048.6</b>	<b>4</b>	<b>97048.6</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж орон нутгийн төсвөөс болон ОНХСангаас авсан санхүүжилтийн зарцуулалтын тооцоог бүрэн шалгах боломжгүй, зөвхөн санхүүгийн тайлан гаргалтыг шалгаж баталгаажууллаа.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 70.9 сая төгрөгийн алдаа илэрч аудитын явцад залруулга хийсэн.Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төлөвлөгөөг 24.9 сая төгрөгөөр, нийт зарлага гүйцэтгэлийг 24.9 сая төгрөгөөр илүү тайлагнасныг залруулав.

Нэмэлт дансаар дамжуулсан 21.0 сая төгрөгийн санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитад ирүүлээгүй тул нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланд бүртгэж залруулав.

Аудитын дүнгээр 314.9 сая төгрөгийн зөрчил илэрч, 0.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 314.1 сая төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөв.

#### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар дараах зөрчилд төлбөрийн акт тогтоов.Үүнд:

1.Ажилтнуудад олгосон 0.8 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаж аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй байна.

## 5.2 Албан шаардлага

Аудитаар дараах зөрчилд албан шаардлага өгөв.Үүнд:

1.Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 61.1 сая төгрөгийн 25 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 75 хувьтай байна.

## 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэхтэй холбоотой асуудал

#### 1.1. Илрүүлэлт:

Албан томилолт, урьдчилгаа, бараа материал, шатахуун зэрэг зардлуудын нийт 182.1 сая төгрөгийн гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

#### 1.2 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх заавар аргачлалын хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөөг 24.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 24.9 сая төгрөгөөр илүү тайлагнасан	1	49771.8			1	49771.8						
Нэмэлт 21.0 сая төгрөгийн санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитад ирүүлээгүй тул нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланд залруулав.	1	21121.2	1	21121.2								

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>Дүн</b>	2	70893.0											
------------	---	---------	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Суутгаагүй урьдчилгааг авлагаар тайлагнаагүй	1	850.0	1	850.0								
Тооцооны данс дамжуулахгүйгэр шууд зардлаар бүртгэж	1	182080.6					1	182080.6				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>182080.6</b>					<b>1</b>	<b>182080.6</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 15 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй	1	61095.2			1	61095.2		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>61095.2</b>			<b>1</b>	<b>61095.2</b>		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>61095.2</b>			<b>1</b>	<b>61095.2</b>		